

Монгол-Германы санхүүгийн хамтын ажиллагаа

Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох төсөл - 2 ба 3 дугаар үе шат

2023 оны 5 дугаар сарын 30 -аас 6 дугаар сарын 15 -нд KfW банкнаас гүйцэтгэсэн үнэлгээний ажлын хурлын тэмдэглэл

2023 оны 5, 6 дугаар сард Нина Отто (Төслийн ахлах менежер, 2023 оны 6 дугаар сарын 5-15), Маттиас Бэктолшайм (БНМ -ийн ахлах зөвлөх, 2023 оны 5 дугаар сарын 30-аас 6 дугаар сарын 7), Карина Ников (БОНН-ийн ахлах мэргэжилтэн, 2023 оны 5 дугаар сарын 30-аас 6 дугаар сарын 7), мөн Фабиан Штахр (Худалдан авалтын зөвлөх, 2023 оны 6 дугаар сарын 5 - 10) нараас бүрдсэн KfW банкны үнэлгээний баг “Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох” төслийн (БОЯБХУАӨДЗТ) 1, 2, 3 дугаар шатны үйл явцын үнэлгээг хийлээ. Байгаль орчин, аялал жуулчлалын яам (БОАЖЯ)-ны ТХГНБЗГ-ын дарга/төслийн захирал Н.Баатарцогт, БОЯБХУАӨДЗТ-ийн төсөл хэрэгжүүлэх нэгж (ТХН) -ийн зохицуулагч М.Болдбаяр, төслийн зөвлөх баг (ЗБ)-аас ТАЗ Др.Александр Градел, KfW банкны орон нутгийн төлөөлөгч Г.Эрдэнэбаясгалан болон ЗБ, ТХН/БОАЖЯ-ны ажилтнууд ажиллалаа. Тус үнэлгээний ажлын үеэр БОАЖЯ-ны сайд Б.Бат-Эрдэнэ, дэд сайд М.Ганбаатар, СЯ-аас Ч.Чимидсүрэн мөн ЭЗХЯ-аас И.Батхүү нартай уулзаж ярилцлаа. Үнэлгээний багийн гишүүд Алтай Таван Богдын байгалийн цогцолборт газар (БЦГ), Хөх сэрхийн дархан цаазат газар (ДЦГ), Монгол Элсний БЦГ, Хар ус нуурын БЦГ, Мянган Угалзат БЦГ, Их говийн ДЦГ-ын Б хэсэг (Баруун Монгол) зэрэг газруудад ажиллалаа. Үнэлгээний нөгөө багийн гишүүд Монгол Улсын өмнөд болон төв хэсэгт орших Хангайн нурууны БЦГ, Орхоны хөндийн БЦГ, Их газрын чулуун БЦГ, Говийн Бага ДЦГ-т ажилласан. Хатагтай Ников, ноён Штахр нар УБ хотод байгаль орчин, нийгмийн эрсдэлийн менежмент, худалдан авалтын асуудлаар ЗБ болон ТХН-тэй голлон ажилласан.

Орон нутагт ажиллах явцад өндөр үр ашигтай, үр бүтээлтэй, тааламжтай орчин нөхцөлийг бий болгосон удирдах ажилтнууд болон бусад бүх хүмүүсийн зочломтгой байдал, дэмжлэгт үнэлгээний багийн зүгээс талархаж байгаагаа илэрхийллээ.

Үнэлгээний багийн зүгээс өгч байгаа мэдэгдэл, тайлбар нь зөвхөн үнэлгээний багийн байр суурийг илэрхийлж байгааг онцлон тэмдэглэв. Тохиролцсон хэлэлцээрийг KfW-ийн удирдлага болон Германы засгийн газар эцэслэн батална.

1. БОЯБХУАӨДЗТ-ийн 1 дүгээр шатны ажлын үнэлэлт, дүгнэлт

1.1. БОЯБХУАӨДЗТ-ийн 1 дүгээр үе шатыг дуусгах

2023 оны 6-р сарын 2-ны байдлаар ойролцоогоор 11,478,000 сая еврог (нийт 11.5 сая еврогоос) энэ үе шатны төлбөрт зориулж KfW-аас шилжүүлсэн. Ингэснээр одоо ойролцоогоор 22,000 евро үлдээд байна. 2022 оны 9-р сарын 26-ны өдөр байгуулсан ЭКО-ын зөвлөхийн 2 дугаар шатны гэрээний нэмэлт өөрчлөлтийн дагуу энэ үлдсэн санхүүжилтийг Зөвлөх-д эргэн тооцох журмаар олгохоор тохиролцсон.

Энэ үе шатны аудитын эцсийн тайланг (2023 оны хувьд доор байгаа 1.2-ыг үзнэ үү) KfW-аас хянаж, зөвшөөрснөөр бүх төлбөр гарсны дараа (өөрөөр хэлбэл дансны үлдэгдэл

тэг евро болсон үед) KfW-аас төслийн 1 дүгээр үе шатыг хаах тухай BMZ-д албан ёсоор мэдэгдэх болно. БОЯБХУАӨДЗТ-ийн 1 дүгээр үе шатны үр дүнд хөндлөнгийн нөлөөллийн томоохон үнэлгээ хийж магадгүй.

1.2. Аудит (БОЯБХУАӨДЗТ-ийн 1, 2, 3 дугаар үе шат)

Аудит: 2022 оны санхүүгийн аудитаар БОЯБХУАӨДЗТ-ийн 1 ба 2 дугаар үе шатанд хамтын ажиллагааны санхүүжилттэй холбоотой ямар нэг зөрчил гараагүй (Хөндлөнгийн аудиторчуудын тайланг үзнэ үү). Энэ 2 үе шатны аудитын тайланг KfW-аас хянаж байна. 2023 онд БОЯБХУАӨДЗТ-ийн 1 үе шатнаас үлдсэн санхүүжилтийн зарцуулалтын эцсийн аудитын тайланг гаргаж, KfW-д хүргүүлэн, үл татгалзах авах шаардлагатай (1.1-ийг үзнэ үү).

1.3. БОЯБХУАӨДЗТ-ийн хүрээнд хэрэгжсэн Орчны бүсийн сан (ОБС)

Төслийн 1 дүгээр үе шатнаас үлдсэн 255,000 еврог одоогоор ОБС-г өргөжүүлэхэд оруулахаар төлөвлөж байна. Тиймээс энэ үе шатанд ОБС-д оруулах нийт хэмжээ нь ойролцоогоор 688,000 евро (2021 онд 430,000 евро, 2023 онд 255,000) байна. Нэмэлт санхүүжилтийг ОБС-ийн хөндлөнгийн үнэлгээ хийх гэрээ байгуулсны дараа шилжүүлнэ. Шилжүүлэг хийгдэхээс өмнө ТХН/ЗБ нь KfW-аас үл татгалзах авна.

Үүний зэрэгцээ ТХН-ээс нэмэлт 255,000 еврог тусгасан дамжин зээлдүүлэх гэрээний (ДЗГ) шинэчилсэн хувилбарыг бэлдэх ба KfW-аас зөвшөөрөл авна. Үнэлгээний үр дүнд хоёр зорилгод ашиглана: а) БОЯБХУАӨДЗТ-ийн 1 дүгээр үе шатны ОБС -ийн горимд тохируулга хийх, б) БОЯБХУАӨДЗТ-ийн 2, 3 дугаар үе шатанд ОБС-г өргөтгөх төлөвлөгөө. Боломжит тохируулгад хамгаалалтын мэргэжилтнүүдийн өгсөн зөвлөмжийг тусгана. Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн зөвлөхүүдийн өгсөн зөвлөмжийг мөн тусгана. Мөн түүнчлэн, үнэлгээний үр дүнд үндэслэн 2, 3 дугаар үе шатны хүрээнд хэрэгжүүлэх ОБС-ийн мониторинг болон үнэлгээний цаашдын ажлын саналыг ЗБ-аас KfW-д хүргүүлнэ.

Үнэлгээний ажлын үеэр Хангайн нуруу, Орхоны хөндийн ОБС-ийн оролцогч талуудтай хэлэлцүүлэг өрнүүлсэн. Харилцан тохиролцсоны дагуу малын тоо болон зээлийн эргэн төлөлтийн схемийг ёсчлон дагаж байгаа ба ОБС-ийн дэмжлэгийн эрэлт хэрэгцээ байгаа санхүүжилтээс давж байгааг нотолж байна.

Эцэст нь хэлэхэд, 2021 оны 7 дугаар сард БОАЖЯ, ТБ, ХЗ болон сумдын төлөөлөгчдийн хооронд гарын үсэг зурсан таван ДЗГ-ний дагуу ДЗГ нь дөрвөн жилийн хугацаанд хүчинтэй байх тул 2025 оны 7 дугаар сард хугацаа нь дуусна. 255,000 орчим еврог нэмж санхүүжүүлэхэд сангийн анх төлөвлөсөн хугацаанд нөлөөлөхгүй. Үнэлгээний үеэр БОЯБХУАӨДЗТ-ийн 1 дүгээр үе шатанд хэрэгжсэн ОБС-ийн үйл ажиллагааг дуусгах эсвэл өргөжүүлэхтэй холбоотой дараагийн алхмуудыг KfW-ийн 2024 онд хийх явцын үнэлгээний үеэр хэлэлцэхээр тохиролцов.

2. БОЯБХУАӨДЗТ-ийн 2, 3 дугаар үе шат

2.1. Төлбөр, санхүүжилттэй холбоотой асуудлууд

2.1.1. Төлбөрийг БОАЖЯ/СЯ-аас гаргах ба еврогоор хийх төлбөрүүд

ТХН-ийн бараа, үйлчилгээний төлбөрийг цаг тухайд нь гаргаж, болзошгүй торгуулиас зайлсхийхийн тулд гүйцэтгэгчийн ирүүлсэн нэхэмжлэхийг цаг алдалгүй хянаж, батлахыг үнэлгээний багийн зүгээс БОАЖЯ/СЯ-аас хичээнгүйлэн хүсэж байна. Төлбөрийг еврогоор хийх тохиолдолд (шууд төлбөрийн хялбаршуулсан журмын дагуу хийсэн гэрээний хувьд) гэрээлэгч нь шилжүүлгийг холбогдох ямар банкуудаар дамжуулахыг

ТХН-д мэдэгдэх ёстой. Эдгээр дэлгэрэнгүй мэдээллийг гүйцэтгэгчийн нэхэмжлэлд тусгах шаардлагатай. Үүнээс гадна, ЗБ-аас БОАЖЯ-д ирүүлсэн хагас жилийн тайланг хүлээн авснаас хойш гурван долоо хоногийн дотор хянан үзэж, KfW-д мэдэгдэл өгснөөр, KfW нь ЗБ-ийн төлбөрийг шилжүүлэх боломжтой гэдгийг үнэлгээний багийн зүгээс сануулж байна.

2.1.2. Монголын талын хөрөнгө оруулалт

2020 оны 4 дүгээр сарын 24-ний өдрийн БОЯБХУАӨДЗТ-ийн 2 дугаар үе шатны Тусгай гэрээний 3 дугаар нэмэлт, өөрчлөлтөд зааснаар Монгол Улсын Засгийн газар нь БОЯБХУАӨДЗТ-ийн 2, 3 дугаар үе шатанд ТХН, Тусгай хамгаалалттай газар нутгийн ашиглалт, засвар үйлчилгээний (БОАЖЯ-аас энэ зорилго бүхий төсөв) зардал, мөн ТХГН-ийн системд БОАЖЯ-аас оруулах хөрөнгө оруулалт (жишээлбэл, ТХГН-ийн дэд бүтцийн хувьд) гэх мэтэд шаардлагатай 14,8 тэрбум төгрөгийг тус тус санхүүжүүлэхийг үүрэг болгосон. БОАЖЯ-аас ТХГН-т өгдөг ердийн төсвийг монгол талын хөрөнгө оруулалтын нэг хэсэг гэж тооцохгүй (БОЯБХУАӨДЗТ-ийн 2, 3 дугаар үе шатны Тусгай гэрээг үзнэ үү). 2021, 2023 оны ТХН-ийн санхүүжилтэд БОАЖЯ-аас одоогийн байдлаар ойролцоогоор 2,5 тэрбум төгрөг хуваарилсан ба 2022 онд Дарьганга, Ачит нуурын ХЗ-ны байр барихад 1,1 тэрбум төгрөг оруулсан. Хэрэв монгол талын хөрөнгө оруулалтад нэмэх зүйл байгаа бол 9 дүгээр сарын 15-ны дотор явуулахыг БОАЖЯ-аас үнэлгээний багаас хүслээ. ТХГН-ын ашиглалт болон засвар үйлчилгээний зардалд илүү төсөв шаардлагатай байгааг үнэлгээний баг цохож, 2019-2021 онуудад БОАЖЯ-аас энэ зорилгодоо хүрэхийн тулд маш шаргуу ажилласан шиг ажиллахыг зөвлөж байна.

2.1.3. Татвар болон импортын төлбөр

БОЯБХУАӨДЗТ-ийн 2, 3 дугаар үе шатны Санхүүжилтийн гэрээний дагуу Германы Санхүүгийн тусламжийн хөрөнгийг хүлээн авагчийн төлөх татвар болон бусад төрийн хураамжийг санхүүжүүлэхэд (жишээ нь, БОЯБХУАӨДЗТ-ийн машин гэх мэт) -д ашиглахгүй.

2.2. Худалдан авалт

2.2.1. Цаашид хийх хөрөнгө оруулалтыг төлөвлөх: 2022, 2023 онд ТХГН-дад чухал чухал хөрөнгө оруулалтууд (машин, судалгааны болон үндсэн тоног төхөөрөмж, дүрэмт хувцас, онлайн уулзалтын төхөөрөмж, трактор) хийгдсэн байна. Газар дээр нь хийсэн үнэлгээний явцад тэдгээр тоног төхөөрөмж нь ашиглахад бэлэн, зөв зохистой ашиглагдаж байгаа ба ХЗ-ын ажилтнуудад урам зориг өгч, менежментийн чадавхад тодорхой хувь нэмэр оруулж байгааг харуулсан. Хурдан үр дүнд хүрэх амьжиргаа дэмжих арга хэмжээ (хүлэмж, усалгааны систем) нь орлого нэмэгдүүлэхэд тус нэмэр болж байгаа ч биологийн олон янз байдлыг хамгаалахтай тодорхой холбоогүй байна (2022 оны 5-р сарын 9-нд гарын үсэг зурсан ХТ-ийн 2.6-р хэсгийг харна уу). Хэрэв эдгээр төрлийн ажлыг өргөжүүлэх бол анхаарах ёстой зүйл юм. Үнэлгээний багийн зүгээс эдгээр ололт амжилтыг гаргасан ТХН/ЗБ-т баяр хүргэж, үр дүнтэй ажлаа улам эрчимжүүлэхийг хүсэж байна.

ТХН/ЗБ-т ойрын болон дунд хугацаанд хэрэгжүүлэх цаашдын үйл ажиллагаа/хөрөнгө оруулалтаа төлөвлөж эхлэхийг үнэлгээний багаас зөвлөж байна. Цаашдын хөрөнгө оруулалтын төлөвлөгөө нь ХЗ-дын хэрэгцээ шаардлагад (тэдгээрийн менежмент төлөвлөгөөнд орсон) үндэслэсэн, төслийн зорилгууд, зорилтот дөрвөн үр дүндээ хүрэхэд хувь нэмэр болох, мөн БОЯБХУАӨДЗТ-ийн 4 бүрэлдэхүүн хэсэгт тохиролцсон санхүүжилтийн хувь хэмжээтэй тохирч байх ёстой. Шаардлагатай бол, амжилттай болсон гэж 2 талын тооцож байгаа өмнө хийгдсэн хөрөнгө оруулалтуудыг (БОЯБХУАӨДЗТ-ийн 1, 2, 3 дугаар үе шат) байгаль орчин, нийгмийн нөлөөллийн

зөвлөхүүдийн оролцоотойгоор шинэ тендер (жишээ нь, байгаль хамгаалагчийн хувцас, эко кабинет, тоног төхөөрөмж, амьжиргааг дэмжих гэх мэт) зарлах замаар өргөжүүлэх нь зүйтэй гэж харилцан тохиролцов. Кластерийн арга барилыг цаашид хэрэгжүүлэхээ больсон тул хөрөнгө оруулалтыг голчлон ТХГН-ийн ХЗ-д болон орчны бүсийн иргэдэд чиглүүлэх ёстой. Гэсэн хэдий ч ЗБ-аас аймгийн БОАЖГ, УСГ-дад цаашид дэмжлэг үзүүлэх эсэх талаар санал хүсэлтээ 6-р сарын 20-ны дотор KfW-д хүргүүлнэ. Орон нутгийн түвшинд амьжиргаа, нийгэм-эдийн засгийн хөгжлийг дэмжих үйл ажиллагаа нь биологийн олон янз байдлыг хамгаалахтай уялдаатай байх бөгөөд цаашид KfW-тэй ярилцаж шийднэ. ЗБ/ТХН нь 2023 оны 9-р сарын 15-ны дотор амьжиргааг дэмжих үйл ажиллагааг хэрхэн хэрэгжүүлэх талаар богино хэмжээний санал бэлтгэнэ. Цаашид ГОУХАН-ээс боловсруулсан тохирох ажлыг БОЯБХУАӨДЗТ-ийн хүрээнд санхүүжүүлэхэд анхаарахыг үнэлгээний багаас санал болгож байна.

БОЯБХУАӨДЗТ-ийн бүтээгдэхүүн, үр дүнгийн багцад заасны дагуу төсөл нь төслийн бүс нутаг дахь ХЗ-дын МТ-г боловсруулах ба/эсвэл шинэчлэхэд дэмжлэг үзүүлнэ (ХЗ нь энэ ажлыг бүхэлд нь хариуцна). Очсон газрууд МТ-тэй байв. Гэсэн хэдий ч БОАЖЯ-аас МТ-г батлах (БОЯБХУАӨДЗТ-ийн 2, 3 дугаар үе шатны хүрээнд боловсруулсан МТ) болон МТ-г 5-аас 10 жил болгон сунгахаар төлөвлөж байгаа зэрэгтэй холбоотой асуудлууд зарим газарт хүлээгдэж байна. МТ-г цаг тухайд нь баталж байхыг үнэлгээний багаас БОАЖЯ-нд зөвлөж байна (хөтөлбөрийн 1-ээс 3-р үр дүнг харна уу).

Өмнөх мониторингийн үеэр үнэлгээний багаас БОЯБХУАӨДЗТ-ийн хүрээнд олгож байгаа бүх бараа болон ажлыг удаан ашиглаж, тогтвортой байдлыг хангах зорилгоор тэдгээрийн ашиглалт, засвар үйлчилгээний зардлыг гаргахыг шаардаж байгаа ба түүнийг БОАЖЯ хариуцахыг онцлов.

2.2.2. Худалдан авалт, үйл ажиллагааны төлөвлөгөө

Худалдан авалт, үйл ажиллагааны төлөвлөгөөг (ХАТ ба YAT) БОАЖЯ/СЯ-аас шаардлагатай уян хатан байдлаар авч үзэхийг үнэлгээний багаас хүсэж байна. Нөхцөл байдал, хэрэгцээ гэх мэтээс хамаарч өөрчлөлтүүд гарч болзошгүй тул бүх үйл ажиллагааг төлөвлөгөөнд заасан хугацаанд хэрэгжүүлэх боломжгүй. Энэхүү үнэлгээний ажлын үр дүнтэй уялдан ХАТ-д зарим нэмэлт өөрчлөлт оруулж, KfW-аас үл татгалзах авна гэж хүлээж байна.

2.2.3. Бараа материал ба түгээлтийн жагсаалт: ТХН нь БОЯБХУАӨДЗТ-ийн 2 дугаар үе шатны хүрээнд хийгдсэн ажлууд (бараа, ажил, үйлчилгээ)-ыг харуулсан хөрөнгө оруулалтын жагсаалтыг байршил/ТХГН/орчны бүсээр, мөн ямар хэмжээтэй хийгдсэнийг шинэчлэн бүртгэнэ. Тус жагсаалтыг ТХН-ээс тогтмол шинэчилж байх шаардлагатай бөгөөд ингэснээр уг жагсаалт хэзээд бэлэн байх боломжтой юм. Цаашлаад, тендер бүрийн ажлын даалгавартай цуг түгээлтийн жагсаалтыг гаргахаар тохиролцсон ба хөрөнгө оруулалтыг ямар ашиг хүртэгчид (жишээ нь, ТХГН эсвэл иргэд) хүлээж авахыг тодорхой зааж өгсөн байна. Эдгээр жагсаалт нь хүлээн авагчийн хэрэгцээ шаардлагад нийцсэн, тендер зарлахаас өмнө ЗБ-аар хянуулсан байна. Түгээлтийн жагсаалтад ямар нэг өөрчлөлт орохоор бол KfW-аас үл татгалзах авна. Одоогийн байдлаар түгээлтийн жагсаалт нь бэлэн болоогүй олон тооны тендер байна. Эдгээр жагсаалтыг аль болох түргэн гаргаж, тендерүүдийг хойшлуулахгүй явуулахыг үнэлгээний багийн зүгээс хүсэж байна.

2.2.4. 2022 онд хийгдсэн худалдан авалтын шалгалтын үр дүн: KfW 2022 онд хийгдсэн худалдан авалтуудаас сонгон хяналт шалгалт хийгээд дуусаж байгаа бөгөөд үр дүнг цаг тухайд нь хуваалцах болно. Энэхүү хяналт шалгалтаас гарсан аливаа дүгнэлтийг цаашдын худалдан авалтад харгалзан үзнэ.

2.2.5. ТҮХ-оос ажлын даалгаврыг хянах: Хөрөнгө оруулалт болон зөвлөх үйлчилгээний ажлын даалгаврыг KfW-аас үл татгалзах авсны дараа ТҮХ өөрчлөхгүй.

2.2.6. Худалдан авалттай холбоотой гарсан гомдлыг шийдвэрлэх: KfW-ийн худалдан авалтын удирдамжийн дагуу, худалдан авалттай холбоотой гомдлыг тендер хариуцсан төсөл хэрэгжүүлэгч агентлаг, энэ тохиолдолд БОАЖЯ хариуцна. Гэсэн хэдий ч Монголын түншүүдэд (БОАЖЯ/СЯ) иймэрхүү төрлийн гомдлыг шийдвэрлэх тодорхой журам одоогоор алга байна. Энэхүү тодорхой бус байдлаас шалтгаалан БОЯБХУАӨДЗТ-ийн 2 дугаар үе шатанд (МОНҮТШ-03/22) гомдлыг хянан шийдвэрлэхээс өмнө тендерийн хүчинтэй байх хугацаа дууссан тул дор хаяж 1 тендер цуцалсан. Үнэлгээний ажлын дараа KfW-ийн зүгээс манай худалдан авалтын удирдамжид заасан гомдол, тендерийн хүчинтэй байх хугацааг сунгахтай холбоотой заалтуудыг тусгасан албан бичиг бэлтгэж БОАЖЯ болон СЯ-д хүргүүлнэ. Энэ хугацаанд Монголын түншүүд маань тендерийн гомдлын хороо байгуулсныг сайшааж, тус хорооны гишүүдийг худалдан авах ажиллагааны чиглэлээр мэргэшсэн байхыг зөвлөж байна. Тендертэй холбоотой бүх гомдлыг KfW-д хүргэж, гомдлын агуулгыг судалж үзсэнээр БОАЖЯ-аас шийдвэрлэх шаардлагатайг үнэлгээний багаас онцоллоо.

2.2.7. Шууд гэрээ: Үнэлгээний багийн зүгээс шууд гэрээний тендер шалгаруулалтын (ШГ) журмыг цаашид ашиглах эсэх нь тодорхойгүй байгааг тэмдэглэв. KfW-тэй өөрөөр тохиролцоогүй тохиолдолд ШГ-г KfW-ээс үл татгалзах аван, журмын дагуу цаашид хэрэгжүүлнэ.

2.2.8. Туршлага судлах аялал: БОЯБХУАӨДЗТ-ийн санхүүжилтээс санхүүжих аливаа аялал нь тодорхой санал дээр тулгуурласан байх ба KfW-ээс үл татгалзах авна. Тус саналыг БОАЖЯ-наас бэлтгэж, туршлага судлах аяллын хэрэгцээ, агуулга, зорилгыг тодорхойлж, зардал багатайгаар (жишээ нь, очих бүс нутгаа сонгох, хангалттай хугацаанд бэлтгэх) зохион байгуулна. Туршлага судлах аялалд оролцогчид нь байгаль хамгаалагчид/ХЗ-ын удирдлагууд болон ТХН эсвэл ЗБ болон БОАЖЯ-аас сонгогдсон төлөөлөгчдөөс бүрдэж, зохицуулалт хийх, хянах үүрэгтэй. Саналыг ЗБ хянаж үзээд, KfW-аас үл татгалзах авна.

2.3. Барилга байгууламж

2.3.1. Ховдын ББССМТ: Санал болгож буй төвийн хэрэгцээний нарийвчилсан үнэлгээ, үйл ажиллагааны нарийвчилсан/сэтгэлд хүрсэн үзэл баримтлалыг өнөөг хүртэл боловсруулж KfW-д хянуулаагүй байгаа тул цаашид шийдвэр гаргах үндэслэл байхгүй байна (2022 оны ХТ-ийг харна уу). БОАЖЯ нь 2023 оны 8-р сарын сүүлээс өмнө санал болгож буй барилгыг хэрхэн үргэлжлүүлэх талаар санал бэлтгэнэ.

2.3.2. Говийн Их ДЦГ “БЗ хэсгийн олон үйл ажиллагаат ХЗ-ны барилга: ОУТГ болон ЗБ-тай холбогдсон ч KfW-ийн зүгээс төлөвлөж буй олон үйлдэлт барилгын техникийн зураг төсөлд үл татгалзах өгөөгүй байгаа бөгөөд эдгээр зурагт тодорхой өөрчлөлт оруулахыг ОУТГ-ээс хүссэн. Хэрэв БОАЖЯ зөвшөөрвөл зургийг өөрчлөхтэй холбоотой зардлыг БОЯБХУАӨДЗТ-ийн санхүүжилтээс гаргаж болно. Үнэлгээний багийн зүгээс БОАЖЯ-д а) KfW-ийн асуултуудын хариулт болон АҮАЗ-ын үзэл баримтлалыг 2023 оны 6-р сарын 25-ны дотор ирүүлэх, б) туслах барилгуудын зураг төсөл, дагалдах барилгууд болон тоног төхөөрөмжийн санхүүжилтийг тодорхой болгох шаардлагатай байна гэдгийг дахин сануулахыг хүсэж байна. ЗБ/ТХН-ээс 2023 оны 7-р сарын 10-ны дотор барихаар төлөвлөж байгаа барилгын шинэчилсэн зургийг KfW-д хүргүүлэх бөгөөд цаашид хэлэлцэх шаардлагатай нээлттэй асуудлуудыг онцолно

2.3.3. Байгаль хамгаалагчийн байр: Байгаль хамгаалагчийн байрны тендерийг бусад барилгын ажлын тендерээс хамааралгүйгээр гүйцэтгэнэ. Холбогдох бэлтгэл ажил нь шаардлагатай орчин, нийгмийн нөлөөллийн журмыг дагаж мөрдөнө. Нэмэлт ХЗ-дын барилгын санхүүжилтийн талаар KfW болон БОАЖЯ хоёр хэлэлцүүлгээ үргэлжлүүлэх болно.

2.4. Байгаль орчин, нийгмийн (БОН) эрсдэлийн менежмент

Байгаль орчин, нийгмийн эрсдэлийн менежментийн уялдаа холбоо байхгүйн улмаас одоогийн байдлаар БОН-ийн эрсдэлийн удирдлагын гүйцэтгэл бага зэрэг хангалтгүй байна. Үнэлгээний ажлын үеэр БОН-ийн эрсдэлийн менежментийн төлөвлөгөөг шинэчлэх, диаграмм/хяналтын хуудас боловсруулах замаар а) Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн менежментийг хэрэгжүүлэх б) Гомдол барагдуулах механизмыг нэвтрүүлэх, в) оролцогч талуудын оролцоо/харилцаа холбоо г) (б) ба (в)-г эрхэмлэсэн БОН -ийн эрсдэл ба нөлөөллийн менежмент, уялдаа холбоог сайжруулахаар тохиролцлоо. Цаашид сар бүр БОН-ийн уулзалтууд (ТХН ба ЗБ), улирал тутам KfW-тэй уулзалт хийж, дотооддоо (сар бүр) БОН-ийн цахим сургалт зохион байгуулахаар болов. Цаашлаад, ажил давхардахаас зайлсхийж, чанарын менежментийг сайжруулахын тулд БОН-ийн эрсдэлийн менежменттэй холбоотой төлөвлөлт, хэрэгжилт, хяналт, тайлан зэргийг гаргахдаа ЗБ болон ТХН-д ажиллаж буй бүх үндэсний болон олон улсын зөвлөхүүд харилцан уялдаатай ажиллахыг үнэлгээний багаас хүсэж байна. БОН-ийн эрсдэлийг бууруулах арга хэмжээг мөн ажлын худалдан авалтад тусгах шаардлагатай. Үнэлгээний үеэр тохиролцсон БОН-ийн эрсдэлийн менежментийн ажлыг багтаасан 2023, 2024 онуудад хэрэгжүүлэх үйл ажиллагааны нарийвчилсан төлөвлөгөөг боловсруулсан ба түүний дагуу ЗБ болон ТХН-ээс хэрэгжүүлнэ.

2.5. Хяналт шинжилгээ, үнэлгээ (ХШҮ)

ЗБ-аас ирүүлдэг техникийн тайлангуудаар дамжуулан БОЯБХУАӨДЗТ-ийн үр нөлөө/хөтөлбөрийн зорилт, гарсан урт хугацааны үр дүн/төслийн зорилт, түүнчлэн хөтөлбөрийн үр дүн, бүтээгдэхүүний багцад тодорхойлсон богино хугацааны үр дүнгийн талаар KfW-д тогтмол мэдээлэх шаардлагатай. Шалгуур үзүүлэлт бүрийн хувьд суурь болон зорилтот үзүүлэлтийг тогтооно. Шинэчилсэн үзүүлэлт тус бүрийг KfW-тэй тохиролцсоны дагуу тодорхой хугацаанд ирүүлнэ. Шалгуур үзүүлэлт тус бүрийн мониторинг-т тавигдах шаардлагуудын жагсаалт бүхий мониторингийн төлөвлөгөөг ЗБ-аас бэлтгэж байгаа бөгөөд үл татгалзах авахаар KfW-д хүргүүлнэ. ЗБ-аас бэлтгэсэн техникийн тайланг KfW болон БОАЖЯ-д хүргүүлэхээс өмнө ТХН-д өгнө.

2023 оны 6 дугаар сарын 13-нд Улаанбаатар хотод гарын үсэг зурав

БОАЖЯ-г төлөөлж

М.Ганбаатар
БОАЖЯ-ны дэд сайд

KfW үнэлгээний багийг төлөөлж

N. Otto
Нина Отто
Төслийн ахлах менежер/ Удирдагч

*The English version of the
form is the binding one.
In case of derivations
the English version prevails.*